



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар A/50

Ховд

Г Түр чөлөө олгох тухай Г

Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, аймгийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.23-ын “в” заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндээ эмчлүүлэх шаардлагатай болсон аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн Х.Ганболдыг өөрийн хүсэлтийг үндэслэн 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай цалингүй чөлөө олгосугай.

2. Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн Х.Ганболдын чөлөөтэй байх хугацаанд түүний хариуцаж байсан албан үүргийг зохих журмын дагуу зохицуулан бусдад түр орлон гүйцэтгүүлэхээр шийдвэрлүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

3. Х.Ганболдын чөлөөтэй байх хугацааны цалингийн болон бусад холбогдох тооцоог хийж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын санхүү, аж ахуйн тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д даалгасугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД

